# КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2025 оны 03 сарын 18 №25/02 Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ийн өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам, ТУЗ-ийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хурлын эчнээ санал хураалтыг тус тус үндэслэн Крипто Үндэстэн ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Крипто Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид "Хурал" гэх)-ыг 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Сэнтрал Тауэр, 17 давхарт ХУРАЛДУУЛСУГАЙ.

2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус БАТАЛСУГАЙ.

3. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөр ТОГТООСУГАЙ.

4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн дотор ХҮРГҮҮЛСҮГЭЙ.

5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2025 оны 04 дүгээр сарын 9-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ДАМЖУУЛСУГАЙ.

6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, зэрэг холбогдох бусад баримт бичгийг бэлэн болгож, 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад ХҮРГҮҮЛСҮГЭЙ.

7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 14:00 цагаар тасалбар БОЛГОСУГАЙ.

8. Хурлын даргаар Крипто Үндэстэн ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганхуягийг ТОМИЛСУГАЙ.

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр ТОМИЛСУГАЙ. Үүнд:

**Хурал зохион байгуулах комиссын дарга:**

Крипто Үндэстэн ХК, ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг

**Хурал зохион байгуулах комиссын гишүүд:**

Крипто Үндэстэн ХК-ийн гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил
Крипто Үндэстэн ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Уранцэцэг
Крипто Үндэстэн ХК-ийн ерөнхий нягтлан бодогч Б.Тэлмүүн

10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр ТОМИЛСУГАЙ. Үүнд:

**Тооллогын комиссын дарга:**

Ө.Бямбагэрэл (Ард Секюритиз ҮЦК ХХК)

**Тооллогын комиссын гишүүд:**

Ч.Даваацэрэн (Ард Секюритиз ҮЦК ХХК)
А.Эрхбилгүүн (Ард Секюритиз ҮЦК ХХК)

11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хурал зохион байгуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахад шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг хурал зохион байгуулах комисст ДААЛГАСУГАЙ.

12. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил-д ДААЛГАСУГАЙ.

ДАРГА Ч.ГАНХУЯГ

УЛААНБААТАР ХОТ КРИПТО ҮНДЭСТЭН ХК КТА223 2105853 9022051025

*/ТУЗ-ийн 2025 оны 03 сарын 18-ны өдрийн 25/02 тоот тогтоолын 1-р хавсралт/*

УЛААНБААТАР ХОТ КРИПТО ҮНДЭСТЭН ХК КТА223 2105853 9022051025

## 2025 ОНЫ 4 САРЫН 30-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ КРИПТО ҮНДЭСТЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
6. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах тухай
7. ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх тухай
8. ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай
9. Бусад асуудал;

*/ТУЗ-ийн 2025 оны 3 сарын 18-ны өдрийн 25/02 тоот тогтоолын 2-р хавсралт/*

ҮЛААНБААТАР ХОТ КРИПТО ҮНДЭСТЭН ХК

**КРИПТО ҮНДЭСТЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС (ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №3,6,7 )**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: ___________________________

Регистрийн дугаар: _______________________________________

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: ________________________________

Энэхүү санал авах хуудсаар 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Сэнтрал Тауэр, 17 давхарт хуралдах "Крипто Үндэстэн ХК"-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

| № | Хэлэлцэх асуудал | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|---|
| 1 | 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах. | | | |
| 2 | ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах тухай. | | | |
| 3 | ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх. | | | |

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Завсарласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.
5. Саналыг саналын хуудсаар эсвэл цахимаар өгөх боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____________________

Санал авах хуудсыг үйлдсэн 2025 оны ... -р сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/ Үгүй

Тооллогын комиссын дарга _________________ /………………………………./

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

______________________________________________________________________________

______________________________________________________________________________

______________________________________________________________________________

/ТУЗ-ийн 2025 оны 3 сарын 18-ны өдрийн 25/02 тоот тогтоолын 2-р хавсралт/

**КРИПТО ҮНДЭСТЭН ХК-ИЙН**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС**
**(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №8)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: ______________________________

Регистрийн дугаар: ______________________________________

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____________________________

Энэхүү санал авах хуудсаар 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Сэнтрал Тауэр, 17 давхарт хуралдах "Крипто Үндэстэн ХК"-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

**Санамж:** ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг **кумулятив аргаар** хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй (100*9гишүүн=900) болох болно. Хувьцаа эзэмшигч нь саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй. Хувилбар А: Хувьцаа эзэмшигч нь нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно. Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч нь нийт 900 саналын эрхийн 400 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 4 хүртэл нэр дэвшигчид, 500 эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 5 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.

| № | ТУЗ-ийн нэр дэвшигчдийн овог нэр | Нэр дэвшигчид өгөх саналын тоо |
|---|---|---|
| Ердийн гишүүд | | |
| 1 | | |
| 2 | | |
| 3 | | |
| 4 | | |

| | | |
|---|---|---|
| 5 | | |
| 6 | | |
| Хараат бус гишүүд | | |
| 1 | | |
| 2 | | |
| 3 | | |

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Завсарласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.
5. Саналыг саналын хуудсаар эсвэл цахимаар өгөх боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг ______________

Санал авах хуудсыг үйлдсэн 2025 оны ... -р сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/ Үгүй

Тооллогын комиссын дарга ______________ /………………………………/

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

______________________________________________

______________________________________________

______________________________________________

*/ТУЗ-ийн 2025 оны 3 сарын 18-ны өдрийн*
*25/02 тоот тогтоолын 3-р хавсралт/*

**КРИПТО ҮНДЭСТЭН ХК-ИЙН ХУВЬЦАА**
**ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 3 сарын 18-ны өдрийн 25/02 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарлаж байна.

**Компанийн оноосон нэр**: Крипто Үндэстэн ХК (CNF)

**Хурал хуралдуулах газар:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Сэнтрал Тауэр, 17 давхарт
**Огноо**: 2025 оны 4 сарын 30-ны өдрийн 11:00 цагт

**Санал өгөх хэлбэр:** Ард Апп (Ard App) болон цаасаар хосолсон хэлбэрээр саналаа өгнө.

2025 оны 4 сарын 30-ны өдөр хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид урьдчилсан санал өгөх боломжтой. Саналыг Ард Секюритиз ҮЦК ХХК компанийн Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1304 тоот хаягаар дамжуулан авах ба саналын хуудас хүлээн авах сүүлийн хугацаа 2025 оны 4 сарын 29-ний өдрийн 14:00 цагаар тасалбар болгоно.

**Хурлын хэлэлцэх асуудал**:

1. 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
6. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах тухай
7. ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх тухай
8. ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай
9. Бусад асуудал;

**Бүртгэлийн өдөр**: 2025 оны 4 сарын 11-ний өдөр

**Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл, хавсралт;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал;

Хувьцаа эзэмшигч та 2025 оны 3 сарын 26-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд ажлын цагаар өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандаж хурлын материалтай танилцах боломжтой.

**Хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 17 давхар

**Утас:** 77078080, 80109755

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

*/ТУЗ-ийн 2025 оны 3 сарын 18-ны өдрийн 25/02 тоот тогтоолын 4-р хавсралт/*

КРИПТО ҮНДЭСТЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл, хавсралт;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал;

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн
377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа
эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 1-р хавсралт

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

| | |
|---|---|
| Компанийн нэр | КРИПТО ҮНДЭСТЭН ХК |
| Компанийн хаяг | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Холдингсын байр, 2 давхарт байрлах Крипто Үндэстэн ХК |
| Утас | 77078080, 80109755 |
| Хурал хуралдах өдөр, цаг | 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цаг |
| Хурал хуралдах газар /хаяг, байршил/ | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Сэнтрал Тауэр, 17 давхарт |
| Хурлын төрөл | Ээлжит |
| Хурал зарлагч | ТУЗ-ийн гишүүд |
| Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо | 2025-03-18 |
| Олон нийтэд зарлах огноо | 2025-03-25 |
| Бүртгэх өдөр | 2025-04-11 |
| Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо | 2025-03-26 |
| Хүргүүлсэн огноо | 2025-03-21 |
| Хурлын даргын нэр | Ч.Ганхуяг |
| Тооллогын комиссийн дарга, гишүүдийн нэр | Ө.Бямбагэрэл,Ч.Даваацэрэн, А.Эрхбилгүүн |
| Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/ | |
| Баримт, бичгийн хуудсын тоо | ................ хуудас |

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ /...................................... /

УЛААНБААТАР ХОТ КРИПТО ҮНДЭСТЭН ХК